



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эргэлтийн бус хөрөнгөд бүртгэлтэй, 874,260.00 (найман зуун далан дөрвөн мянга хоёр зуун жаран) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг Сангийн яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбат, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, "Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал Б.Ундрам нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



000739



Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын 2020 оны 07
дугаар сарын 06-ний өдрийн 341
дүгээр тогтоолын хавсралт

"Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" ТӨҮГ-ын эргэлтийн
бус хөрөнгөд бүртгэлтэй Сангийн яаманд шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/ д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашигла лтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо)	2019	м.кв	27	874,260.00
	Нийт дүн				874,260.00 (найман зуун далан дөрвөн мянга хоёр зуун жаран)